



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/06/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Аудитор: О.Баярмаа
Утас: 261740 Цахим хаяг: bayamaao@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Мөнгөн оршдос Аудит ХХК
Захирал: Ц.Таванчулуу
Утас: 99177464 Цахим хаяг: tavanchuluu.ts@moaudit.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	11
3. Аудитын тайлан	13
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	14
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	14
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	14
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	15
4.4 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	17
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
5.1 Шилэн дансны мэдээлэл	17
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
8. Аудитын илрүүлэлт	20
8.1 Залруулсан алдаа	20
8.2 Албан шаардлага	20
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21
10. Хавсралт: Албан шаардлага	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХСУХАТАҮЗЗ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/1627
танай _____-ны № _____-т

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН
АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Ж.БАТСУУРЬ ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй нийт 670.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа эсвэл нийтээрээ материаллаг боловч өргөн тархаагүй, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Засгийн газрын 2020 оны 211 тоот тогтоолын 3 дугаар заалт, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.3, Сангийн сайдын 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан заавар, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, УСНББОУС-15 Санхүүгийн хэрэглүүртэй нийцэхгүй, эрх үүрэг, үнэн зөв болон тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд Засгийн газрын 2020 оны "Коронавируст халдварын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай" 211 дүгээр тогтоолын дагуу төрөөс хариуцах цэвэр, бохир усны санхүүжилтэд 120,081.0 сая төгрөгийг олгосон байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 1,323.8 сая төгрөг байхаар баталсан байна. Тайлант оны гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлого /Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төлөх зохицуулах үйлчилгээний хураамж/ 1,376.4 сая төгрөгийг төвлөрүүлж, үйл ажиллагааны урсгал зардалд 1,192.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	838,148,837.15	33,117,469,048.66
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	168,645,811.44	289,963,740.21
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	1,164,041.81	68,250.81
31110	Төгрөг	1,164,041.81	68,250.81
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	167,481,769.63	289,895,489.40
3121	Төгрөг	167,481,769.63	289,895,489.40
31211	Арилжааны банкин дахь харилцах	65,173,423.17	244,140,472.38
31212	Арилжааны банкин дахь харилцах- тусгай зориулалттай	-	35,788,999.56
31213	Арилжааны банкин дахь харилцах-ЖМС	42,931.37	30,831.37
31214	Арилжааны банкин дахь Нэмэлт санхүүжилтийн харилцах	102,265,415.09	9,935,186.09
33	АВЛАГА	87,398,387.08	32,808,837,367.82
335	Бусад авлага	87,398,387.08	32,808,837,367.82
3351	Байгууллагаас авах авлага	87,398,387.08	32,806,841,820.82
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	1,995,547.00
34	УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	570,933,800.00	2,380,850.00
34600	Урьдчилгаа тооцоо	570,933,800.00	2,380,850.00
35	БАРАА МАТЕРИАЛ	11,170,838.63	16,287,090.63
351	Түүхий эд материал	583,393.00	1,514,393.00
35110	Тусгай зориулалттай материал	583,393.00	1,514,393.00
354	Хангамжийн материал	10,587,445.63	14,772,697.63
35410	Бичиг хэргийн материал	3,062,519.40	1,726,189.40
35420	Аж ахуйн материал	3,399,878.00	5,550,802.00
35440	Түлш, шатах тослох материал	3,042,821.23	6,355,583.23
35460	Хүнсний материал	31,727.00	89,623.00
35470	Бусад хангамжийн материал	1,050,500.00	1,050,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	186,088,493.89	835,541,199.42
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	186,088,493.89	835,541,199.42
392	Биет хөрөнгө	175,371,933.77	835,541,199.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	00.00	670,933,800.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	195,400,000.00	195,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(80,072,499.80)	(107,612,499.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	62,595,890.00	81,276,590.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(30,402,423.16)	(43,700,285.21)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,862,840.00	76,913,342.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(32,921,613.27)	(39,579,487.57)
39214	Бусад үндсэн хөрөнгө	869,990.00	869,990.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(163,000.00)	(163,000.00)
39217	Ном	1,202,750.00	1,202,750.00
393	Биет бус хөрөнгө	10,716,560.12	00.00
39301	Программ хангамж	31,834,920.00	31,834,920.00

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн
2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

39302	Хуримтлагдсан элэгдэл	(21,118,359.88)	(31,834,920.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,024,237,331.04</u>	<u>33,953,010,248.08</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	400,000.01	32,582,511,120.91
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	400,000.01	32,582,511,120.91
413	Өглөг	400,000.01	32,582,511,120.91
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.01	00.01
4136	Бусад өглөг	400,000.00	32,582,511,120.90
41361	Байгууллагад төлөх өглөг	400,000.00	32,582,511,120.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,023,837,331.03	1,370,499,127.17
51	Засгийн газрын хувь оролцоо	1,023,837,331.03	1,370,499,127.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	20,000.00	20,000.00
51101	Өмч: - төрийн	20,000.00	20,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,023,817,331.03	1,370,479,127.17
51210	Өмнөх үеийн үр дүн	447,669,722.37	1,023,817,331.03
51220	Тайлант үеийн үр дүн	576,147,608.66	346,661,796.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,024,237,331.04</u>	<u>33,953,010,248.08</u>

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,619,830,757.30	122,044,628,460.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,619,830,757.30	1,927,826,121.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,619,830,757.30	1,927,826,121.00
120002	Хүүгийн орлого	2,728,114.70	
120003	Торгуулийн орлого		4,700,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,444,495,408.60	1,923,126,121.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,443,923,029.60	1,415,162,850.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	205,001.00	420,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	367,378.00	354,171.00
120009	Бусад орлого	1,172,607,234.00	507,189,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	120,116,802,339.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	120,116,802,339.00
131002	Засгийн газрын санхүүжилт- Төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөр	00.00	120,116,802,339.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,043,683,148.64	121,697,966,663.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,043,683,148.64	121,662,006,341.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,005,017,308.64	1,580,973,001.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	859,788,567.58	907,899,167.83
210101	Үндсэн цалин	833,038,567.58	877,349,167.83
210105	Гэрээт ажлын хөлс	26,750,000.00	30,550,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,619,016.67	117,498,439.50
210201	Тэтгэврийн даатгал	78,592,800.67	79,702,448.50
210202	Тэтгэмжийн даатгал	8,580,366.00	11,578,255.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,864,293.00	7,205,424.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,420,828.00	1,531,726.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,160,729.00	17,480,586.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,979,000.00	72,744,000.00
210304	Байрны түрээс	77,979,000.00	72,744,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	213,491,104.96	140,945,182.12
210401	Бичиг хэрэг	186,026,030.00	92,168,330.00
210402	Тээвэр, шатахуун	3,526,343.00	4,020,478.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,220,050.96	11,647,394.12
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,609,973.00	33,108,980.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	108,708.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,166,440.00	12,652,970.00
210604	Урсгал засвар	3,166,440.00	12,652,970.00
2107	Томилолт, зочны зардал	48,644,283.00	47,721,406.00
210701	Гадаад албан томилолт	7,814,600.00	00.00
210702	Дотоод албан томилолт	40,829,683.00	47,721,406.00

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн
2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	605,744,203.73	139,216,406.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	586,253,735.13	128,082,730.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,645,052.00	3,043,080.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	391,611.00	360,866.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,751,600.00	4,975,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	317,205.60	299,730.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	363,000.00	389,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,584,692.70	142,295,430.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,911,240.00	81,622,590.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,455,896.00	2,460,543.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	45,217,556.70	58,212,296.47
212	ТАТААС	00.00	120,081,033,339.44
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	00.00	120,081,033,339.44
212101	Төрөөс хариуцах цэвэр,бохир усны төлбөр	00.00	120,081,033,339.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,665,840.00	35,960,322.50
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	1,016,022.50
213102	ОУБ-ын гишүүний татвар	00.00	1,016,022.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,665,840.00	34,944,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	38,665,840.00	34,944,300.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>576,147,608.66</u>	<u>346,661,796.14</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>576,147,608.66</u>	<u>346,661,796.14</u>

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<u>20,000.00</u>	<u>447,669,722.37</u>	<u>447,689,722.37</u>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,000.00	447,669,722.37	447,689,722.37
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	576,147,608.66	576,147,608.66
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<u>20,000.00</u>	<u>1,023,817,331.03</u>	<u>1,023,837,331.03</u>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,000.00	1,023,817,331.03	1,023,837,331.03
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	346,661,796.14	346,661,796.14
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<u>20,000.00</u>	<u>1,370,479,127.17</u>	<u>1,370,499,127.17</u>

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,598,659,732.70</u>	<u>121,920,562,206.08</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,595,885,479.70	1,803,759,867.08
120	Нийтлэг татварын бус орлого	2,595,885,479.70	1,803,759,867.08
120002	Хүүгийн орлого	2,728,114.70	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,462,573,431.00	1,803,759,867.08
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,462,302,430.00	1,376,785,287.08
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	271,001.00	490,000.00
120009	Бусад орлого	1,130,583,934.00	426,484,580.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,774,253.00	120,116,802,339.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	120,116,802,339.00
131002	Засгийн газрын санхүүжилт-Төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөр	00.00	120,116,802,339.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,774,253.00	
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,774,253.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,578,462,706.94</u>	<u>121,762,513,075.31</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,578,462,706.94	121,720,066,902.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,534,928,143.94	1,639,033,563.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	887,446,237.58	871,321,991.60
210101	Үндсэн цалин	495,156,801.58	702,627,991.60
210102	Нэмэгдэл	20,009,807.00	23,520,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,602,000.00	54,912,000.00
210104	Урамшуулал	35,805,900.00	59,712,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	302,871,729.00	30,550,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,753,599.67	108,640,100.15
210201	Тэтгэврийн даатгал	87,753,599.67	108,640,100.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,334,000.00	72,744,000.00
210304	Байрны түрээс	77,334,000.00	72,744,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,898,462.96	34,614,001.12
210401	Бичиг хэрэг	9,325,650.00	7,971,400.00
210402	Тээвэр, шатахуун	5,900,000.00	10,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,575,550.96	11,647,594.12
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,097,262.00	4,595,007.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,077,003.00	13,354,970.00
210604	Урсгал засвар	6,052,003.00	13,354,970.00
2107	Томилолт, зочны зардал	52,606,520.00	43,175,475.00
210701	Гадаад албан томилолт	10,049,390.00	00.00
210702	Дотоод албан томилолт	42,557,130.00	43,175,475.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,364,171,476.60	339,707,556.00

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн
2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,335,583,848.00	318,192,880.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,062,600.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,645,052.00	3,043,080.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	391,611.00	360,866.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	23,171,600.00	15,745,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	272,765.60	299,730.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,640,844.13	155,475,469.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,142,550.00	155,475,469.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,498,294.13	00.00
212	ТАТААС	00.00	120,081,033,339.44
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	00.00	120,081,033,339.44
212101	Төрөөс хариуцах цэвэр,бохир усны төлбөр	00.00	120,081,033,339.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,534,563.00	42,446,172.50
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	3,396,872.50
213102	ОУБ-ын гишүүний татвар	00.00	3,396,872.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,534,563.00	39,049,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	43,534,563.00	39,049,300.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	20,197,025.76	158,049,130.77
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	13,933,700.00	36,731,202.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,933,700.00	36,731,202.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,933,700.00	36,731,202.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,933,700.00	36,731,202.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-13,933,700.00	-36,731,202.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	6,263,325.76	121,317,928.77
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	162,382,485.68	168,645,811.44
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	168,645,811.44	289,963,740.21

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

төгрөгөөр

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	төгрөг	2,592,396,406.94	1,323,827,600.00	121,799,244,277.31	(120,475,416,677.31)	
УРСГАЛ ЗАРДАЛ	төгрөг	2,592,396,406.94	1,323,827,600.00	121,799,244,277.31	(120,475,416,677.31)	
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	төгрөг	2,548,861,843.94	1,274,930,800.00	1,675,764,765.37	(400,833,965.37)	131.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	төгрөг	887,446,237.58	738,384,000.00	871,321,991.60	(132,937,991.60)	118.0
Үндсэн цалин	төгрөг	495,156,801.58	569,040,000.00	702,627,991.60	(133,587,991.60)	123.5
Нэмэгдэл	төгрөг	20,009,807.00	23,520,000.00	23,520,000.00	-	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	төгрөг	33,602,000.00	54,912,000.00	54,912,000.00	-	100.0
Урамшуулал	төгрөг	35,805,900.00	59,712,000.00	59,712,000.00	-	100.0
Гэрээт ажлын хөлс	төгрөг	302,871,729.00	31,200,000.00	30,550,000.00	650,000.00	97.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	төгрөг	87,753,599.67	99,681,800.00	108,640,100.15	(8,958,300.15)	109.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	төгрөг	77,334,000.00	84,534,000.00	72,744,000.00	11,790,000.00	86.1
Байрны түрээс	төгрөг	77,334,000.00	84,534,000.00	72,744,000.00	11,790,000.00	86.1
Хангамж, бараа материалын зардал	төгрөг	28,898,462.96	43,158,000.00	34,614,001.12	8,543,998.88	80.2
Бичиг хэрэг	төгрөг	9,325,650.00	8,372,000.00	7,971,400.00	400,600.00	95.2
Тээвэр, шатахуун	төгрөг	5,900,000.00	16,031,400.00	10,400,000.00	5,631,400.00	64.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	төгрөг	9,575,550.96	13,540,400.00	11,647,594.12	1,892,805.88	86.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	төгрөг	4,097,262.00	5,214,200.00	4,595,007.00	619,193.00	88.1
Эд хогшил, урсгал засварын зардал	төгрөг	20,010,703.00	20,000,000.00	13,354,970.00	6,645,030.00	66.8
Урсгал засвар	төгрөг	20,010,703.00	20,000,000.00	13,354,970.00	6,645,030.00	66.8
Томилолт, зочны зардал	төгрөг	52,606,520.00	17,542,000.00	43,175,475.00	(25,633,475.00)	246.1
Дотоод албан томилолт	төгрөг	52,606,520.00	17,542,000.00	43,175,475.00	(25,633,475.00)	246.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	төгрөг	1,364,171,476.60	27,631,000.00	376,438,758.00	(348,807,758.00)	
БГБНАҮТХураамж	төгрөг	1,335,583,848.00		354,924,082.00	(354,924,082.00)	
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	төгрөг	2,062,000.00	3,500,000.00	2,000,000.00	1,500,000.00	57.1
Даатгалын үйлчилгээ	төгрөг	2,645,052.00	4,500,000.00	3,043,080.00	1,456,920.00	67.6

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн
2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо	төгрөг	435,611.00	666,000.00	426,866.00	239,134.00	60.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	төгрөг	23,171,600.00	18,485,000.00	15,745,000.00	2,740,000.00	85.2
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	төгрөг	272,765.60	480,000.00	299,730.00	180,270.00	62.4
Бараа үйлчилгээний бусад зардал	төгрөг	30,640,844.13	244,000,000.00	155,475,469.50	88,524,530.50	63.7
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	төгрөг	-	-	120,081,033,339.44	(120,081,033,339.44)	
Төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөр	төгрөг	-	-	120,081,033,339.44	(120,081,033,339.44)	
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	төгрөг	43,534,563.00	48,896,800.00	42,446,172.50	6,450,627.50	86.8
Засгийн газрын урсгал шилжүүлэг	төгрөг	-	4,943,800.00	3,396,872.50	1,546,927.50	68.7
ОУБ-ын гишүүний татвар	төгрөг	-	4,943,800.00	3,396,872.50	1,546,927.50	68.7
Бусад урсгал шилжүүлэг	төгрөг	43,534,563.00	43,953,000.00	39,049,300.00	4,903,700.00	88.8
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	төгрөг	43,534,563.00	43,953,000.00	39,049,300.00	4,903,700.00	88.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	төгрөг	2,598,659,732.70	1,323,827,600.00	121,920,562,206.08	(120,596,734,606.08)	
Нийтлэг татварын бус орлого	төгрөг		1,323,827,600.00	1,803,759,867.08	(479,932,267.08)	
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	төгрөг	2,595,885,479.70	1,323,827,600.00	1,803,759,867.08	(479,932,267.08)	
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	төгрөг	1,462,302,430.00	1,323,827,600.00	1,376,785,287.08	(52,957,687.08)	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	төгрөг	2,999,115.70		490,000.00	(490,000.00)	
Нэмэлт үйл ажиллагааны орлогоос санхүүжих	төгрөг	1,130,583,934.00		426,484,580.00	(426,484,580.00)	
Тусламж, санхүүжилтийн орлого	төгрөг			120,116,802,339.00	(120,116,802,339.00)	
Улсын төвлөрсөн төсвөөс	төгрөг			120,116,802,339.00	(120,116,802,339.00)	
Засгийн газрын санхүүжилт-Төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөр	төгрөг			120,116,802,339.00	(120,116,802,339.00)	
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	төгрөг	2,774,253.00				
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	төгрөг	2,774,253.00				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	төгрөг	162,382,485.68		168,645,811.44		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	төгрөг	168,645,811.44		289,963,740.21		
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ						
АЖИЛЛАГСАДЫН ТОО		22	32	29	3	90.6
Удирдах ажилтан		1	5	5	-	100.0
Гүйцэтгэх ажилтан		20	21	20	1	95.2
Үйлчлэх ажилтан		1	6	4	2	66.7

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарны 16-наас 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Мөнгөн оршдос аудит ХХК-ийн ахлах аудитор Х.Фариза, аудиторын туслах Г.Содбилэг нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Б.Отгонцэцэг, захирал Ц.Таванчулуу нар хэрэгжүүлсэн.

ХСУХАТАҮЗЗ нь 2021 оны санхүүгийн тайлангаа Мөнгөн оршдос аудит ХХК-д 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 01/71 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

ХСУХАТАҮЗЗ-ийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Барилга хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/131 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсэг ХСУХАТАҮЗЗ-ийн үйл ажиллагаа, санхүүгийн гүйцэтгэлд хэсэгчилсэн хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Коронавируст халдварын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 211 дүгээр тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны “Түр журам батлах тухай” 242 дугаар тушаалыг хэрэгжүүлэх явцад ХСУХАТАҮЗЗ нь УСУГ болон Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч хувийн хэвшлийн 78 ААН-ийн хоорондын тооцоогоор төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөрийг 12,595.0 сая төгрөгөөр давхардуулан олгосныг тогтоож, давхардуулан олгогдсон төлбөрийн тооцоог нарийвчлан гаргаж холбогдох байгууллагаас нь суутган төлүүлэх арга хэмжээг 2022 оны 01 дүгээр сарын 30-ны дотор хэрэгжүүлэх, мөн зөрчлийг арилгах төлөвлөгөө гарган зохион байгуулж ажиллах, биелэлтийг сар бүр тайлагнаж байхыг үүрэг болгосон байна.

Давхардуулан олгогдсон төлбөрийн тооцоог нарийвчлан гаргаж тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ийн дотоодын хэрэглээнд хэрэглэсэн цэвэр, бохир усны төлбөр 384.5 сая төгрөгийг, төрөөс хариуцах төлбөрийн 9, 10 дугаар сарын нэхэмжилсэн дүнгээс 4,905.7 сая төгрөгийг холбогдох байгууллагаас нь суутган төлүүлж, үлдэгдэл төлбөр 7,304.8 сая

төгрөгийг холбогдох 77 ААН-тэй тооцоо нийлж, актаар баталгаажуулж, 2021 оны санхүүгийн тайланд авлагаар бүртгэж, төлж барагдуулах хугацаатай үүрэг өгөгдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Их” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 60 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 2,043.7 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 10.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн зорилго нь Монгол Улсад ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг үр ашигтай явуулах нөхцөл бололцоог бүрдүүлэн, дэлхийн жишигт нийцсэн чанар стандарт бүхий найдвартай, тэгш, хүртээмжтэй үйлчилгээг хот, суурины хэрэглэгчдэд хүргэх, баталгаажуулах оновчтой зохицуулалтыг хийхэд оршино.

ХСУХАТАҮЗЗ-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг усны үйлчилгээний төлбөр, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний тарифыг тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй байна гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн байгууллага, албан газар гэсэн статустай байна. Өмчийг 100 хувь төр эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл нь Монгол Улсын Хот, суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2-т заасны дагуу “Зохицуулах зөвлөл”-ийн дүрмийг Засгийн газрын 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 46 дугаар тогтоолоор, бүтэц, орон тоог 2012 оны

05 дугаар сарын 30-ны өдрийн 183 дугаар тогтоолоор тус тус баталсныг үндэслэн байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн орон тооны бус гишүүдийн цалин, урамшууллыг 0.6 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Хот,суурины ус хангамж,арииутгах татуургын тухай хуулийн 10.1.3 дахь заалт “Тусгай зөвшөөрөл олгох,сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох” ажлын хүрээнд шаардлага хангасан 37 аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг сунган шинээр олгож асуудлыг шийдвэрлэсэн байна.

Хот,суурины ус хангамж,арииутгах татуургын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, Зохицуулах зөвлөлийн 2020 оны 91 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Зохицуулах үйлчилгээний хөлс тооцох аргачлал”-ыг үндэслэн гаргасан ХСУХАТАУ33-ийн 2021 оны 02 тоот тогтоолоор 2021 онд тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төлөх зохицуулах үйлчилгээний хураамжид нийт 1,323.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,376.8 сая төгрөг орлого бүрдүүлж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоол “Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 249 дүгээр тогтоол “Зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төсөв батлах тухай”
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Барилга,хот байгуулалтын сайдын тушаал “Түр журам батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- ХСУХАТАУ33-ийн 2021 оны 02 дугаар тогтоол “Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төлөх зохицуулалтын үйлчилгээний хураамжийн хэмжээг батлах тухай”

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	168,645.8	289,963.7	121,317.9
Авлага	87,398.4	32,808,837.4	32,721,439.0
Урьдчилгаа тооцоо	570,933.8	2,380.9	-568,553.0
Бараа материал	11,170.8	16,287.1	5,116.3
Үндсэн хөрөнгө	186,088.5	835,541.2	649,452.7
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,024,237.3</u>	<u>33,953,010.2</u>	<u>32,928,772.9</u>
Богино хугацаат өр төлбөр	400.0	32,582,511.1	32,582,111.1
Цэвэр өмчийн дүн	1,023,837.3	1,370,499.1	346,661.8
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,024,237.3</u>	<u>33,953,010.2</u>	<u>32,928,772.9</u>

Өмнөх оны үзүүлэлтүүдээс дараах дансуудын үлдэгдэлд материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 290.0 сая төгрөг болж өмнөх оноос 121.3 сая төгрөгөөр өссөн байна. Үлдэгдэлд касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 0.1 сая, банк дахь харилцах дансны үлдэгдэл 289.9 сая төгрөг байна.

Хүснэгт 2. Дансны авлагын үзүүлэлт

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Үлдэгдэл
1	Тусгай зөвшөөрлийн үйлчилгээний хураамжийн авлага	83,204.7
2	Ундны усны чанарын судалгааны ажлын авлага	132,435.0
3	Номны урьдчилгаа авлага	10,000.0
3	Цалингийн авлага	1,995.5
4	Татварын авлага	3,091.1
5	Төрөөс хариуцах цэвэр,бохир усны төлбөрийн авлага	32,578,111.1
	ДҮН	<u>32,808,837.4</u>

Авлагын үлдэгдэлд Зохицуулах үйлчилгээний хураамжийн авлага /Тусгай зөвшөөрөл/ 83.2 сая төгрөг, Ундны усны чанарын судалгааны ажлын авлага 132.4 сая төгрөг, Цалингийн авлага 1.9 сая төгрөг, ХХОАТатварын авлага 3.1 сая төгрөг, Төрөөс хариуцах цэвэр,бохир усны төлбөрийн авлага 32,578.1 сая төгрөгийг эзэлж байна.

Тайлант онд Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Коронавируст халдварын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 211 дүгээр тогтоолын хүрээнд үүссэн Барилга, хот байгуулалтын яам болон аж ахуйн нэгж байгууллагаас авах авлага 32,578.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Тайлант онд Олон улсын байгууллагын гишүүний татвар 2.4 сая төгрөгийн урьдчилгаа тооцоо шилжүүлсэн байна. Урьдчилгаа данснаас тайлант онд ажлын гүйцэтгэлийг дүгнэн, акт үйлдэж 570.9 сая төгрөгийг /Сургалтын байрны урьдчилгаа/ үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 16.3 сая төгрөг болж 5.1 сая төгрөгөөр өссөн нь оны эцэст 5.0 сая төгрөгийн шатахууны худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн мөн хангамжийн материалын үлдэгдлээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 649.5 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Тайлант онд 18.7 сая төгрөгөөр тоног төхөөрөмж, 18.0 сая төгрөгөөр тавилга хэрэгсэл худалдан авсан, барилга, байгууламж 670.9 сая /Сургалтын төвийн барилгын төлбөрт 2020 онд урьдчилгаа 570.9 сая төгрөг, 2021 онд 100.0 сая төгрөг шилжсэн/ төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд Төрөөс хариуцах цэвэр, бохир усны тооцооны өр 32,578.1 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамжийн өр төлбөр 4.4 сая төгрөг байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үйл ажиллагааны зардлыг тайлант хугацааны туршид аккрузал суурьт үндэслэн холбогдох зардлын дансуудад хуримтлуулан бүртгэх, батлагдсан төсөв, эрх бүхий байгууллагын шийдвэр, гэрээг үндэслэж гаргасан зардлыг анхан шатны баримтыг үндэслэн хүлээн зөвшөөрч бүртгэнэ гэж заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад зардал 119,654.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Коронавируст халдварын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 211 дүгээр тогтоолын хүрээнд аж ахуйн нэгж байгууллагад өгөх зардлаас шалтгаалжээ.

4.4 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Засгийн газрын 2020 оны 249 дугаар тогтоолоор Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төсвийг баталсан байна. Тайлант оны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 1,323.8 сая төгрөг байхаар тогтоосон байна.

Тайлант оны гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлого /Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төлөх зохицуулах үйлчилгээний хураамж/ 1,376.4 сая төгрөгийг төвлөрүүлж, үйл ажиллагааны урсгал зардалд 1,192.8 сая төгрөгийг гарсан байна.

Үндны усны чанарын судалгаа, мэдээллийн сан байгуулах, технологийн шийдэл сонгох төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 5 байгууллага, 5 аймагтай гэрээ байгуулж 417.1 сая төгрөгийн нэмэлт орлого бүрдүүлж, 509.5 сая төгрөгийн зардал гарсан байна.

Улсын тэмдэгтийн хураамжийн орлого 9.1 сая төгрөг, татварт 9.5 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Тайлант онд Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын дагуу төрөөс хариуцах цэвэр, бохир усны санхүүжилт 120,116.8 сая төгрөгийг олгож, гүйцэтгэл 120,081.0 сая төгрөг байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

ХСУХАТАУ33 нь тайлант онд нийт 1,950.3 сая төгрөгийн 94 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 161.6 сая төгрөгийн 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна. Мөн гүйлгээ бүрийн анхан шатны баримтыг түүнд холбогдох эрх бүхий этгээдийг шийдвэрийн эх хуулбарын хамт байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлэх” заалтыг хэрэгжүүлээгүй, ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 4.1.9-д “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ хийгдсэнээс хойш зарлагын гүйлгээ бүрт түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбарын хамт 7 хоногийн дотор маягтын дагуу цахимаар нийтэд мэдээлнэ” гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Дээрх хуулиас гадна, тухайлбал Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Засгийн газрын 2020 оны “Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 211 дүгээр тогтоол, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг шалгасан.

1. ЗГ-ын 2020 оны 211 дүгээр тогтоолын хэрэгжилтийг шалгахад Төрөөс хариуцан 2020 оны 12 сараас 2021 оны 10 дугаар сарыг дуустал олгосон ААН, айл өрхийн хэрэглээний усны төлбөрийг өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлтэй жишээгүй 6,542.1 сая төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2020 оны 211 тоот тогтоолын 3-т “Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур, цэвэр, бохир усны эх үүсвэр болон шугам сүлжээ, түгээлтийн техникийн хүчин чадлын боломжит хэмжээтэй уялдуулан үйлчилгээний төлбөр, хураамжийг төрөөс хариуцан төлөх хэрэглээг өмнөх оны мөн үеийн хэрэглээтэй жишиж, энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг одоо мөрдөгдөж байгаа батлагдсан тарифт хэмжээнээс хэтрүүлэхгүй байхаар тус тус тооцож, гүйцэтгэлийг сар бүр хянан баталгаажуулах ажлыг журамлан зохион байгуулах” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: ЗГ-ын 2020 оны “Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 211 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, зөрчил арилгуулах албан шаардлага өгөх.

2. ЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад бэлэг дурсгал мэндчилгээнд 4.0 сая төгрөг, Нийтийн аж ахуйн салбар үүсч хөгжсөний 90 жилийг ойг тохиолдуулан шагналд 8.1 сая төгрөг, баримтат кинонд 8.0 сая төгрөг, тэмдгийн үнэнд 4.0 сая төгрөг, номын үнэнд 7.9 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь ЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3 “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой ААН, байгууллагын ... зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал, мэндчилгээ зэрэг зардлыг гаргахгүй байх”, 1.6 “ЗГ-ын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, салбарын өдөр... зэргийг зохион байгуулахгүй байх”, 1.7 “... салбарын болон байгууллагын үйл

ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх" заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ЗГ-ын Төсвийн хэмнэлтийн талаар хэрэгжүүлж байгаа тогтоолыг шийдвэрийг хэрэгжүүлэх, зөрчил арилгуулах албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны тухай хууль, ЗГ-ын 2020 оны "Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай" 211 дүгээр тогтоол, ЗГ-ын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолуудын зарим заалтуудтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 4,907.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 146.2 сая төгрөгийн зөрчлийг арилгасан, 4,761.3 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж 3.5 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснөөс албан шаардлага 50 хувь, зөвлөмж 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	-	1		1	-	50.0
Зөвлөмж	2	3,500.0	2	3,500.0	-	-	100.0
Нийт дүн	4	3,500.0	3	3,500.0	1	-	75.0

/мянган төгрөг/

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. Зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад илэрсэн доорх асуудлуудыг дараагийн аудитаар шалгах аар шийдвэрлэв. Үүнд:

- ХСУХАТАҮЗЗ нь тайлант онд цалин хөлс, хоол унаа, нэмэгдэл, үр дүнгийн урамшуулалд нийт 736.4 сая төгрөг, нэмэлт үйл ажиллагаа явуулахтай холбоотой 134.9 сая төгрөгийн цалин олгосон байна. 2022 оны санхүүгийн тайланд хийх аудитаар орон тоо, цалин хөлс, нэмэгдэл, үр дүнгийн урамшуулалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх;
- Сургалт, судалгааны төвийн зориулалттай 670.9 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 заалтыг хэрэгжүүлээгүй, гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлсэн асуудлыг шалгах.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 682.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 11.9 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 670.9 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

Залруулагдаагүй 670.9 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 10.2 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 11.9 сая төгрөгийн 3 алдааг залрууллаа. Үүнд:

- Татварын байгууллагад шилжүүлсэн тэмдэгтийн хураамж 9.5 сая төгрөгийг төвлөрүүлэх шилжүүлэг зардлын ангилалд бүртгэснийг залруулж Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж ангилалд бүртгэсэн;
- Олон улсын байгууллагын гишүүний татвар хураамж 2.4 сая төгрөгийг авлагын дансанд бүртгэснийг залруулж Урьдчилж төлсөн төлбөр дансанд бүртгэсэн;
- “Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан”-г /СТ-4А/ буруу тайлагнасныг Сангийн сайдын 2008 оны 352 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт дахь маягтын дагуу тайланг залруулж гаргасан.

8.2 Албан шаардлага

Аудитаар илэрсэн дараах асуудалд албан шаардлага өгөхөөр шийдвэрлүүлэв. Үүнд:

Тус зөвлөл нь сургалт судалгааны төвийн зориулалтаар 230 м² байрыг 290.7 сая төгрөг, 231 м² байрыг 380.2 сая төгрөг, нийт 670.9 сая төгрөгөөр 2 үл хөдлөх хөрөнгийг Легасигрупп ХХК болон иргэн Г.Болорсүхээс тус тус худалдаж авсан 2 хөрөнгийн гэрээний үнэ 1м² тутамд 0.3 сая төгрөг, нийт 89.5 сая төгрөгийн зөрүүтэй байна. Мөн Легасигрупп ХХК-аас худалдаж авсан хөрөнгийн үнийг иргэн Г.Болорсүхийн дансанд шилжүүлсэн, нотариатаар батлуулсан гэрээний үнэ алдаатай, Улсын бүртгэлийн гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлээгүй байна.

Энэ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах, зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэх.

Дээрх алдаа зөрчилд өгөгдсөн албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн
2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс					
							Залруулга		Албан шаардлага		Хуул, хяналтын байгууллагад	
					тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар												
1	ХСУХАТАУ33	АХГ-2022/06/НА-СТА-ТӨА	Санхүүгийн тайланд /СТ-2, СТ-3, СТ-4/ ажил гүйлгээний эдийн засгийн ангиллыг буруу ангилж бүртгэсэн байна. 9.5 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийг төвлөрүүлэх шилжүүлэг зардалд, 2.4 төгрөгийн ОУБ-ын гишүүний татварыг авлагын дансанд бүртгэсэн. Өмчийн өөрчлөлтийн тайланг буруу гаргасан байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", Сангийн сайдын 352 дугаар тушаалын хавсралт, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг хэрэгжүүлэх	3	11,880.9	3	11,880.9				
2	ХСУХАТАУ33	АХГ-2022/06/НА-СТА-ТӨА	Тус зөвлөл нь сургалт судалгааны төвийн зориулалтаар 230 м2 байрыг 290.7 сая төгрөг, 231 м2 байрыг 380.2 сая төгрөг, нийт 670.9 сая төгрөгөөр 2 үл хөдлөх хөрөнгийг Легасигрупп ХХК болон иргэн Г.Болорсүхээс тус тус худалдаж авсан 2 хөрөнгийн гэрээний үнэ 1м2 тутамд 0.3 сая төгрөг, нийт 89.5 сая төгрөгийн зөрүүтэй байна. Мөн Легасигрупп ХХК-аас худалдаж авсан хөрөнгийн үнийг иргэн Г.Болорсүхийн дансанд шилжүүлсэн, нотариатаар батлуулсан гэрээний үнэ алдаатай, Улсын бүртгэлийн гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлээгүй, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ" гэснийг зөрчсөн байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ" гэж заасныг, ТӨБЗГ-ын 2019 оны 271-р тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх	1	670,934.0			1	670,934.0		
Дүн					4	682,814.9	3	11,880.9	1	670,934.0		

**Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн
2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал												
3	ХСУХАТАУ33	АХГ-2022/06/НА-СТА-ТӨА	Төрөөс хариуцан 2020 оны 12 сараас 2021 оны 10 дугаар сарыг дуустал олгосон ААН, айл өрхийн хэрэглээний усны төлбөрийг өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 6,542.1 төгрөгийн хэтрүүлэн олгосон. Засгийн газрын 2020 оны 211 тоот тогтоолын 3-т "Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур, цэвэр, бохир усны эх үүсвэр болон шугам сүлжээ, түгээлтийн техникийн хүчин чадлын боломжит хэмжээтэй уялдуулан үйлчилгээний төлбөр, хураамжийг төрөөс хариуцан төлөх хэрэглээг өмнөх оны мөн үеийн хэрэглээтэй жишиж, энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг одоо мөрдөгдөж байгаа батлагдсан тарифт хэмжээнээс хэтрүүлэхгүй байхаар тус тус тооцож, гүйцэтгэлийг сар бүр хянан баталгаажуулах ажлыг журамлан зохион байгуулах" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.	Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 заалт, Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" зэрэг заалтуудыг үндэслэн зөрчил арилгуулах	1	6,542,052.8			1	6,542,052.8		
4	ХСУХАТАУ33	АХГ-2022/06/НА-СТА-ТӨА	Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудаст "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ"-ний 161.6 сая төгрөгийн 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, мөн гүйлгээ бүрийн анхан шатны баримтыг түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбарын хамт байршуулаагүй байна.	Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 заалт, ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолыг тус тус хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг арилгах, давтан гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах	1	161,637.4			1	161,637.4		
5	ХСУХАТАУ33	АХГ-2022/06/НА-СТА-ТӨА	ЗГ-ын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад бэлэг дурсгал мэндчилгээнд 4.0 сая төгрөг, Нийтийн аж ахуйн салбар үүсч хөгжсөний баярыг тохиолдуулан шагналд 8.1 сая төгрөг, баримтат кинонд 8.0 сая төгрөг, тэмдгийн үнэнд 4.0 сая төгрөг, номын үнэнд 7.9 сая төгрөг зарцуулсан байна.	ЗГ-ын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, зөрчил арилгуулах	1	32,033.4			1	32,033.4		
Дүн					3	6,735,723.6			3	6,735,723.6		
Нийт дүн					7	7,418,538.5	3	11,880.9	4	7,406,657.6		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 610/А0150053

Улаанбаатар хот

АХГ-2022/08/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус Зохицуулах зөвлөл нь сургалт судалгааны төвийн зориулалтаар 230 м2 байрыг 290,725,000 төгрөг, 231 м2 байрыг 380,209,000 төгрөг, нийт 670,934,000 төгрөгөөр 2 үл хөдлөх хөрөнгийг Легасигрупп ХХК болон иргэн Г.Болорсүхээс тус тус худалдаж авсан. Мөн Легасигрупп ХХК-аас худалдаж авсан хөрөнгийн үнийг иргэн Г.Болорсүхийн дансанд шилжүүлсэн, Улсын бүртгэлийн гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлээгүй байна.

Энэ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ" гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн. Хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А195 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ.**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 заалтыг хэрэгжүүлж, холбогдох хууль тогтоомжийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх:


2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга Ж.Батсуурь, Үнэ тариф, санхүүгийн мэргэжилтэн Д.Сэлэнгэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

МӨНГӨН ОРШДОС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

Ц.ТАВАНЧУЛУУ

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3 Засагийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0315_Auditin_2_Gazar-339.Docx

0001081731



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 611/А.0150053

Улаанбаатар хот

АХГ- 2022/08/НЬ-СҮБ-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай" 211 дүгээр тогтоолын хэрэгжилтийг шалгахад Төрөөс хариуцан 2020 оны 12 сараас 2021 оны 10 дугаар сарыг дуустал олгосон аж ахуйн нэгж, айл өрхийн хэрэглээний усны төлбөрийг өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлтэй жишээгүй 6,542,052,791.59 төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын 3-т "Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур, цэвэр, бохир усны эх үүсвэр болон шугам сүлжээ, түгээлтийн техникийн хүчин чадлын боломжит хэмжээтэй уялдуулан үйлчилгээний төлбөр, хураамжийг төрөөс хариуцан төлөх хэрэглээг өмнөх оны мөн үеийн хэрэглээтэй жишиж, энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг одоо мөрдөгдөж байгаа батлагдсан тарифт хэмжээнээс хэтрүүлэхгүй байхаар тус тус тооцож, гүйцэтгэлийг сар бүр хянан баталгаажуулах ажлыг журамлан зохион байгуулах" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн. Хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А\95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Засгийн газрын 2020 оны "Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай" 211 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, холбогдох хууль тогтоомжийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга Ж.Батсуурь, Үнэ тариф, санхүүгийн мэргэжилтэн Д.Сэлэнгэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

МӨНГӨН ОРШДОС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

Ц.ТАВАНЧУЛУУ

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0315_Auditin_2_Gazar-338.Docx

2022.08.15

0001081729



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 612/А0150053

Улаанбаатар хот

АХС-2022/08/НБ-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд бэлэг дурсгал, мэндчилгээнд 3,984,000.00 төгрөг, Нийтийн аж ахуйн салбар үүсч хөгжсөний 90 жилийг ойг тохиолдуулан шагналд 8,100,000.00 төгрөг, баримтат кинонд 8,000,000.00 төгрөг, тэмдгийн үнэнд 4,019,400.00 төгрөг, номын үнэнд 7,930,000.00 төгрөг, нийт 32,033,400.00 төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.3 "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой ААН, байгууллагын ... зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал, мэндчилгээ зэрэг зардлыг гаргахгүй байх", 1.6 "ЗГ-ын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, салбарын өдөр... зэргийг зохион байгуулахгүй байх", 1.7 "... салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх" заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн. Хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А\95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх:

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга Ж.Батсуурь, Үнэ тариф, санхүүгийн мэргэжилтэн Д.Сэлэнгэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

МӨНГӨН ОРШДОС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц НАРАНЧИМЭГ

Д ЭНХДАЛАЙ

Ц ТАВАНЧУЛУУ

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-764230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban_Shaardlaga\2022\0315_Auditin_2_Gazar-337.Docx

0001081723



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 613/А0150053

Улаанбаатар хот

АХГ-2022/08/НА-СТА-ТӨА

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод хуулийн хугацаанд бүрэн байршуулах албан шаардлагыг биелүүлээгүй, тайлант онд шилэн дансны цахим хуудсанд 161,637,402 төгрөгийн 9 ажил, гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, зарлагын гүйлгээ бүрт түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбарын хамт байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 4.1.9 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ хийгдсэнээс хойш зарлагын гүйлгээ бүрт түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбарын хамт 7 хоногийн дотор маягтын дагуу цахимаар нийтэд мэдээлнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдээгдэнэ" Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.2 "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Үнэ тариф, санхүүгийн мэргэжилтэн Д.Сэлэнгэд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга Ж.Батсуурьд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

МӨНГӨН ОРШДОС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Ц.ТАВАНЧУЛУУ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

9006109
9019120396

Z:\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-340.Docx

0001081733

